

**ОРОН НУТГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ГАРЧ
БУЙ ШИЙДВЭРТ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ БАЙДЛЫН
ТАЛААРХ СУДАЛГАА, МЭДЭЭЛЭЛ
(2018-2024)**



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

ОРОН НУТГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДААС ГАРЧ БУЙ ШИЙДВЭРТ ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ БАЙДАЛ (2018-2024)

Судалгааны төрөл: Мэдээлэл, лавлагаа
Судалгааны код: СТ-25/429
Хугацаа: 2025.12.19

Захиалагч: УИХ-ын гишүүн Ж.Золжаргал

Хянасан: Эрдэмтэн нарийн бичгийн дарга Г.Гэсэр

Судалгаа удирдсан: Парламентын хөгжлийн хэлтсийн дарга П.Түмэнцэцэг

Судлаач: Э.Билгүүн, Г.Ган-Эрдэнэ, Б.Эрхэс

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	2
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ	3
УДИРТГАЛ	4
Хураангуй	5
НЭГ.УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАХИМААР ИРСЭН САНАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ	6
1.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай санал	8
1.2. Малын тоо толгойн албан татварын тухай санал	9
1.3. Нэмэлт санал	10
ХОЁР. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ЭРЭМБЛЭГДСЭН БОЛОН БАТЛАГДСАН ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ	11
ГУРАВ.ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС БАТЛАГДСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ	15
ДӨРӨВ.ОРОН НУТАГ БОЛОН НИЙСЛЭЛИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУДАД ИРГЭДЭЭС ИРҮҮЛСЭН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫН МЭДЭЭЛЭЛ	26
4.1. Иргэдээс төрийн байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлын мэдээлэл	26
4.2. Иргэдээс төрийн байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэсэн байдал (2018-2024)	27
4.3. Төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл, гомдлын мэдээлэл	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Цахим саналын жин (аймаг, орон нутгаар)	7
Хүснэгт 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн саналын эзлэх хувь(2023-2026 он).....	8
Хүснэгт 3. Малын тоо толгойн албан татварын саналын эзлэх хувь (2023-2026 он)	9
Хүснэгт 4. Нэмэлт саналын эзлэх хувь (2023-2026 он).....	10
Хүснэгт 5. Орон нутгийн хөгжлийн санд иргэдээс ирүүлсэн саналаас эрэмбэлэгдсэн төслүүдийн тоо (2018-2024 он)	12
Хүснэгт 6. Аймгийн эрэмбэлэгдсэн төслүүдээс ИТХ-аар батлагдсан төслийн тоо (2018-2024 он)	13
Хүснэгт 7. Орон нутгийн хөгжлийн санд иргэдээс ирүүлсэн саналын үндсэн дээр эрэмбэлэгдсэн төслүүд болон ИТХ-аар батлагдсан төслүүдийн зөрүү (аймгаар).....	14
Хүснэгт 8. Орон нутгийн хөрөнгө оруулалт	16
Хүснэгт 9. ОНХС-аар хэрэгжүүлэх арга хэмжээний төсөвт өртөг болон тухайн онд санхүүжүүлсэн хэмжээний хоорондын зөрүү (аймгаар).....	17
Хүснэгт 10. ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөвт өртөг (аймгаар).....	18
Хүснэгт 11. ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний тухайн онд санхүүжүүлсэн хэмжээ	19
Хүснэгт 12. Тухайн оны санхүүжилтэд аймгуудын эзлэх жин.....	20
Хүснэгт 13. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан санхүүжилт, хөрөнгө оруулалтын төрлөөр.....	25
Хүснэгт 14. Орон нутгийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдол (2018-2024 он).....	26
Хүснэгт 15. Нийслэлийн 9 дүүргийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн нийт өргөдөл, гомдол (2018-2024 он).....	27
Хүснэгт 16. Орон нутгийн төрийн байгууллагад ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж хариу өгсөн байдал (2018-2024 он)	27
Хүснэгт 17. Нийслэлийн 9 дүүрэгт иргэдээс төрийн байгууллагуудад ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэж хариу өгсөн байдал (2018-2024 он).....	28
Хүснэгт 18. Төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, хариу өгсөн байдал (аймаг, нийслэлээр).....	28
Хүснэгт 19. Орон нутгийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, хариу өгсөн байдал хувиар (2018-2024 он)	29
Хүснэгт 20. Орон нутгийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл, гомдол (2018-2024 он)	29
Хүснэгт 21. Нийслэлийн 9 дүүргийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл, гомдол (2018-2024 он).....	30
Хүснэгт 22. Төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл, гомдлын хэмжээ (2018-2024 оны дундаж, Нийслэлийн 9 дүүрэг болон 12 аймаг).....	30

Хүснэгт 23. Орон нутгийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл, гомдлын хувь.....	30
Хүснэгт 24. Нийслэлийн 9 дүүрэгт төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэх хугацаа болоогүй өргөдөл, гомдол (2018-2024 он)	31

ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1. Улсын хэмжээний цахим саналын мэдээлэл (2023-2026 он).....	6
График 2. Улсын хэмжээний цахим саналын мэдээлэл (2023-2026 он, аймаг, нийслэлээр)	7
График 3. Аймаг, орон нутгийн хөгжлийн санд иргэдээс ирүүлсэн саналын үндсэн дээр эрэмбэлэгдсэн төслүүд болон ИТХ-аас батлагдсан төслүүдийн зөрүү.....	12
График 4. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан төсөвт өртөг болон санхүүжилт, тэдгээрийн зөрүү (төгрөгөөр)	15
График 5. ОНХС-аар санхүүжүүлсэн нийт дүн аймаг, нийслэлийн эзлэх хувь	20
График 6. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан санхүүжилт, төрлөөр (2018-2024 он)	21
График 7. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан санхүүжилт, салбараар (хувиар)	23
График 8. Орон нутгийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, хариу өгсөн байдал (2018-2024 оны дундаж)	28

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлын гишүүнээс ирүүлсэн захиалгын дагуу Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ болон орон нутгийн төрийн байгууллагуудад ирүүлсэн иргэдийн өргөдөл, гомдлын талаарх тоон мэдээллийг Улсын Их Хурлын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа хөгжлийн хүрээлэнд лавлагаа хэлбэрээр нэгтгэн боловсруулав.

Судалгааны зорилго: Орон нутгийн төрийн байгууллагуудаас гарч буй шийдвэрүүдэд иргэдийн оролцооны түвшинг үнэлэх зорилготой бөгөөд үүнтэй холбоотой мэдээллийг Сангийн яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас газраас авч, нэгтгэн боловсруулах замаар парламентын хяналт болон хууль тогтоох үйл ажиллагаанд мэдээллээр хангаж дэмжлэг үзүүлэх.

Судалгааны хамрах хүрээ: Энэхүү лавлагаанд Сангийн яамнаас ирүүлсэн 21 аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан төслүүд (2018-2024), Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, Улсын хэмжээний цахим саналын тоо болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн 12 аймаг, 9 дүүргийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон мэдээллийг хамруулан боловсруулсан болно.

Судалгааны бүтэц:

1. Улсын хэмжээнд цахимаар ирсэн саналд хийсэн шинжилгээ;
2. Орон нутгийн хөгжлийн санд эрэмбэлэгдсэн болон батлагдсан төслийн талаарх мэдээлэл;
3. иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас батлагдсан төслүүдийн санхүүжилтийн талаарх мэдээлэл;
4. Орон нутаг болон нийслэлийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын талаарх мэдээлэл.

Судалгааны арга зүй: Мэдээлэл лавлагааг Сангийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас албан бичгээр ирүүлсэн тоон мэдээлэл, мөн эдгээр байгууллагын цахим хуудсанд нийтэлсэн тайлан, мэдээнд тулгуурлан боловсруулсан. Цуглуулсан мэдээллийг ойлгомжтой байдлаар хүргэхийн тулд хүснэгт, графикаар үзүүлж, дүн шинжилгээ хийсэн болно.

Түлхүүр үг: Орон нутгийн хөгжлийн сан, цахим санал, өргөдөл, гомдол

Хураангуй

Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) нь Монгол Улсын аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд хэрэгжих хөрөнгө оруулалтын шийдвэр гаргалтад иргэдийн оролцоог хангах гол хэрэгсэл бөгөөд 2013 оноос мөрдөгдөж эхэлсэн. Тус сангийн үндсэн зорилго нь орон нутгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх, бүс нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах, иргэдийн амьдрах орчныг сайжруулахад оршино. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан (ОНХНС)-ийн эх үүсвэрийг НӨАТ, ашигт малтмал болон газрын тосны нөөц ашигласны төлбөр, хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийн орлого зэрэг улсын төсвийн тодорхой хувиас бүрдүүлдэг бөгөөд Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор баталсан аргачлалаар жилийн төсөвт хуваарилалт хийдэг.¹

ОНХС-ийн үйл ажиллагаа нь Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль болон төрийн худалдан авалтын тогтолцоотой уялдсан журмаар зохицуулагддаг. Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт нь баг, хорооны Засаг дарга, иргэдийн Нийтийн хурал, аймаг, нийслэл болон бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал зэрэг оролцогчдын хамтын шийдвэр гаргалтад тулгуурладаг нь иргэдийн оролцоог бодитой хэрэгжүүлэх механизм болж байна.

ОНХС-ийн хөрөнгөөр орон нутгийн дэд бүтцийг сайжруулах, нийтийн эзэмшлийн талбайн тохижилт, гэрэлтүүлэг, бэлчээрийн менежмент, инженерийн хийцтэй худаг гаргах, усан сан, булаг, шанд хамгаалах зэрэг олон салбарын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэн хэрэгжүүлж байгаа нь орон нутгийн хөгжлийн бодлого, иргэдийн хэрэгцээнд тулгуурласан үр өгөөжтэй санхүүжилтийн хэлбэр болж байна.

Тайланд 2018-2024 оны хооронд иргэдээс ирүүлсэн саналын тоо, саналын төрөл, эрэмбэлэгдсэн саналуудын хэмжээ, ИТХ-аас батлагдсан төслүүдийн тоо, төсөөлсөн төсөвт өртөг болон тухайн онд санхүүжих дүнгийн үзүүлэлтүүдийг харьцуулан нэгтгэсэн болно. Мөн салбар, аймаг, хөрөнгө оруулалтын төрөл тус бүрээр санхүүжилтийн бүтэц, төсөл хэрэгжилтийн явцыг судалж, орон нутгийн хөгжлийн сангийн нөөц хуваарилалтын хандлагыг тодорхойлсон. Мөн орон нутгийн болон нийслэлийн төрийн байгууллагуудад иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын тоон мэдээллийг шинжилж, дүгнэсэн болно.

Энэхүү тайлан нь орон нутгийн төсөв, хөгжлийн бодлогын чанарыг сайжруулах, иргэдийн оролцоог бодитой, үр нөлөөтэй болгох, санхүүгийн нөөцийг илүү оновчтой хуваарилах зэрэг дараагийн шатны бодлогын шийдвэр, зөвлөмж боловсруулахад суурь мэдээлэл болно.

Судалгаанд ашигласан мэдээллийн эх сурвалжууд болох Сангийн яам болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн албан ёсны баримт, тайлан, тоон мэдээллийн эх хувилбаруудыг энэ тайлангийн хавсралтад файл хэлбэрээр багцлан хүргүүлэв.

¹ Орон нутгийн хөгжлийн сангийн цахим хуудас. Хандах: <https://tusuv-oronnutag.mof.gov.mn/?p=117>

НЭГ.УЛСЫН ХЭМЖЭЭНД ЦАХИМААР ИРСЭН САНАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Орон нутгийн хөгжлийн сан 2023 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2023 он хүртэл иргэдийн саналыг цаасан хэлбэрээр авч ирсэн. Сангийн яамнаас өгсөн албан хариунд 2023 оноос өмнөх цаасан саналын мэдээллийг ангилан нэгтгэх боломжгүй гэж мэдэгдсэн тул өмнөх жилүүдийн нарийвчилсан тоон мэдээлэл бүрдүүлэх боломжгүй байна. Харин 2023 оноос цахим санал хүлээн авах тогтолцоо хэрэгжиж эхэлснээр иргэдийн саналыг ангилсан мэдээллийг ирүүлсэн тул ОНХС-нд иргэдээс ирүүлсэн саналын судалгаанд 2023-2026 оны өгөгдлийг ашиглан боловсруулалт хийв.


ОНХС-ийн санал авах үйл явцыг цахимжуулах хүрээнд 2022 онд гар утасны “ОНХС” аппликейшнийг хөгжүүлж, ашиглалтад нэвтрүүлсэн. Тус аппликейшнээр иргэдээс ирүүлсэн саналуудыг хөгжлийн бодлого, төлөвлөлт, малын тоо толгойн албан татварын зарцуулалт, нэмэлт санал гэсэн гурван үндсэн ангиллаар нэгтгэн Сангийн яаманд хүргүүлдэг зохицуулалт бүрдсэн байна.

Цахим санал хүлээн авах үйл явц жил бүрийн 6 дугаар сарын 25-ны өдөр хүртэл үргэлжилдэг бөгөөд энэхүү тайланд 2023-2026 оны саналын мэдээллийг боловсруулан шинжилсэн болно. 2026 оны санал хураалтын мэдээлэл нь 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл хүлээн авсан саналуудыг хамардаг тул уг тайланд 2026 онд иргэдээс ирүүлсэн цахим саналын мэдээлэл багтсан болно.

Улсын хэмжээнд 2023-2026 онд цахимаар ирүүлсэн саналын тоог харахад хэлбэлзэлтэй байна. 2023 онд 220,656 санал бүртгэгдсэн бол 2026 онд саналын тоо 405,821 болж, гурван жилийн хугацаанд 84%-аар өссөн нь иргэд цахимаар саналаа өгч оролцох байдал нэмэгдэж байгааг харуулж байна.


Цахим саналуудыг ангиллаар нь авч үзвэл, хөгжлийн бодлого, төлөвлөлттэй холбоотой санал хамгийн өндөр хувийг эзэлж, нийт саналын 94.8%-аас 96.9%-ийг эзэлж байна. Нэмэлт санал 2023, 2025 онд нийт саналын 2.5-2.8%-ийг эзэлж байсан бол 2024, 2026 онд өсөлттэй байж 3.9-4%-д хүрсэн. Харин малын тоо толгойн албан татварт хамаарах санал 2023, 2025, 2026 онд нийт саналуудын 0.4-0.6%-ийг эзэлсэн бол 2024 онд 1.2% эзэлж байжээ.

График 1. Улсын хэмжээний цахим саналын мэдээлэл (2023-2026 он)



2023-2026 онд цахимаар ирсэн саналуудыг Улаанбаатар хот болон аймаг, орон нутгаар харьцуулан хувиар доорх графикт харуулав. 2023 онд цахим саналын 10 санал тутмын 9 нь Улаанбаатар хотод 1 нь орон нутагт ногдож байсан бол 2024 онд 10 санал тутмын 4 нь Улаанбаатар хотод, 6 нь орон нутагт болж өөрчлөгджээ. Улмаар 2025 онд 10 санал тутмын 3 нь Улаанбаатар хотод, 7 нь орон нутагт болж нэмэгдсэн. Харин 2026 онд 10 санал тутмын 5 нь Улаанбаатар хотод, 5 нь орон нутагт болж тооны харьцаа ойртсон байна.

График 2. Улсын хэмжээний цахим саналын мэдээлэл (2023-2026 он, аймаг, нийслэлээр)



Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

Улаанбаатар хотын цахим саналын тоо дүүрэг тус бүрийн мэдээлэл ирээгүй бөгөөд нийслэлийн хэмжээнд 2023 онд 190,056, 2024 онд 147,135, 2025 онд 77,246, 2026 онд 214,261 цахим санал ирсэн байна.

Аймаг, орон нутгийн хэмжээнд 2023 онд 30,600, 2024 онд 211,512, 2025 онд 163,166, 2026 онд 191,560 цахим санал ирсэн байна. 21 аймагт ирсэн цахим саналыг он тус бүрээр 100% гэж тооцож харвал, Баянхонгор, Дорнод, Хөвсгөл, Хэнтий гэсэн 4 аймаг иргэдээс ирсэн цахим саналын тоогоор тогтмол тэргүүлсэн байна. Харин 2023 онд Өвөрхангай, 2024 онд Дундговь, 2025 онд Завхан, 2026 онд Сүхбаатар аймгууд тус тус тэргүүлжээ.

Хүснэгт 1. Цахим саналын жин (аймаг, орон нутгаар)

№	Аймаг	Нийт			
		2023 он	2024 он	2025 он	2026 он
1	Архангай	4%	3%	1%	0.30%
2	Баян-Өлгий	1%	1%	1%	0.20%
3	Баянхонгор	21%	14%	11%	20%
4	Булган	1%	3%	4%	2%
5	Говь-Алтай	4%	5%	4%	4%
6	Говьсүмбэр	0.05%	2%	0.20%	1%
7	Дархан-Уул	0.10%	1%	1%	0.10%
8	Дорноговь	3%	3%	2%	0.40%
9	Дорнод	22%	14%	17%	17%
10	Дундговь	0.50%	8%	3%	4%
11	Завхан	2%	8%	5%	1%

12	Орхон	0.10%	1%	0.10%	0.01%
13	Өвөрхангай	5%	5%	3%	4%
14	Өмнөговь	3%	2%	1%	1%
15	Сүхбаатар	2%	3%	2%	6%
16	Сэлэнгэ	1%	1%	2%	1%
17	Төв	1%	3%	2%	3%
18	Увс	0.10%	1%	1%	0.30%
19	Ховд	2%	1%	1%	1%
20	Хөвсгөл	4%	10%	13%	20%
21	Хэнтий	24%	13%	27%	15%
Нийт		100%	100%	100%	100%

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

ОНХС-ийн цахим саналын тоон мэдээллийг хөгжлийн бодлого төлөвлөлт, малын тоо толгойн албан татвар, нэмэлт санал гэсэн гурван ангиллаар бүлэглэн, тухайн ангиллын санал жил бүр нийт саналын хэдэн хувийг эзэлж байгааг тооцон, 21 аймгийн хэмжээнд тус бүрээр нь дараах байдлаар боловсруулав.

1.1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай санал

2023 онд Улсын хэмжээний цахим саналын дунджаар 71%-ийг “Хөгжлийн бодлого, төлөвлөлт”-ийн талаарх санал эзэлж байсан бол 2024, 2025 онд 91%, 2026 онд 88%-ийг эзэлж байна. Он тус бүрээр цахим саналын эзлэх жингээр өндөр аймгуудыг харвал,

- 2023 онд Баянхонгор, Ховд, Дорноговь, Говь-Алтай аймгууд болон Улаанбаатар хот 95-аас дээш хувь байгаа нь хамгийн өндөр;
- 2024 онд Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Өмнөговь, Завхан, Хөвсгөл, Сэлэнгэ аймгууд болон Улаанбаатар хот 95-аас дээш хувь байгаа нь хамгийн өндөр;
- 2025 онд Хэнтий, Дундговь, Баянхонгор зэрэг аймаг 98-аас дээш хувь байгаа нь хамгийн өндөр;
- 2026 Хэнтий, Ховд, Баянхонгор зэрэг аймаг 98-аас дээш хувь байгаа нь хамгийн өндөр байна.

Хүснэгт 2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн саналын эзлэх хувь(2023-2026 он)

№	Аймаг	Хөгжлийн бодлого төлөвлөлт			
		2023 он	2024 он	2025 он	2026 он
1	Архангай	82.8%	93.2%	90%	88.8%
2	Баян-Өлгий	75%	85%	95.1%	93.4%
3	Баянхонгор	98.4%	97.7%	98.9%	99%
4	Булган	59.6%	94.1%	97.5%	93.4%
5	Говь-Алтай	92.6%	89.6%	95.5%	91.2%
6	Говьсүмбэр	-	96.9%	67.2%	95.5%
7	Дархан-Уул	-	92.8%	95.8%	74.1%
8	Дорноговь	97.6%	96%	96.2%	94.6%
9	Дорнод	96.7%	91.7%	96.3%	96.5%
10	Дундговь	77.5%	94.7%	98%	96.8%
11	Завхан	88.9%	96%	94.4%	92.4%
12	Орхон	-	90%	70.9%	-
13	Өвөрхангай	91%	92%	96.1%	94.5%
14	Өмнөговь	90.4%	95.6%	96.2%	96.5%
15	Сүхбаатар	90.1%	85.3%	85.7%	91%
16	Сэлэнгэ	82.1%	95.4%	95.9%	81.2%
17	Төв	76.5%	88.8%	93.6%	85.3%

18	Увс	-	49.7%	48.5%	78%
19	Улаанбаатар	97.4%	96.6%	97.6%	96.1%
20	Ховд	98%	86.8%	95.2%	98.5%
21	Хөвсгөл	92.5%	95.6%	96.5%	90%
22	Хэнтий	92.2%	94.7%	99.1%	99.2%
Дундаж		71.8%	90.8%	90.9%	87.5%

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

1.2. Малын тоо толгойн албан татварын тухай санал

2023 онд Улсын хэмжээний цахим саналын дунджаар 8%-ийг “Малын тоо, толгойн албан татвар”-ийн талаарх санал эзэлж байсан бол 2024 онд 3%, 2025, 2026 онд 2%,-тай байна.

- 2023 онд малын тоо толгойн албан татвартай холбоотой саналын идэвх хамгийн өндөр түвшинд хүрч, Увс, Дархан-Уул, Булган, Орхон, Баян-Өлгий зэрэг аймгуудад нийт саналын 10-аас дээш хувийн саналыг эзэлсэн байна.
- 2024, 2025 онд Увс аймагт малын тоо толгойн албан татвартай холбоотой санал хамгийн өндөр;
- 2026 онд Орхон аймагт малын тоо толгойн албан татвартай холбоотой санал хамгийн их ирсэн байна.

Хүснэгт 3. Малын тоо толгойн албан татварын саналын эзлэх хувь (2023-2026 он)

№	Аймаг	Малын тоо толгойн албан татвар			
		2023 он	2024 он	2025 он	2026 он
1	Архангай	7.6%	0.9%	3.7%	4%
2	Баян-Өлгий	10.6%	3.1%	1.1%	1.7%
3	Баянхонгор	0.3%	0.5%	0.3%	0.1%
4	Булган	20.6%	1.8%	0.4%	1.3%
5	Говь-Алтай	4.1%	2.1%	1.6%	1.3%
6	Говьсүмбэр	7.1%	0.4%	0.3%	0.4%
7	Дархан-Уул	21.7%	2.3%	0.8%	2%
8	Дорноговь	0.6%	0.6%	0.7%	0.5%
9	Дорнод	0.5%	1.9%	0.8%	0.6%
10	Дундговь	7.9%	2.2%	0.7%	0.7%
11	Завхан	5.1%	1.7%	1.3%	4.2%
12	Орхон	16.7%	3.9%	3.9%	11.1%
13	Өвөрхангай	3.2%	2.1%	0.8%	0.7%
14	Өмнөговь	2.7%	1%	0.8%	0.8%
15	Сүхбаатар	1.3%	1.5%	0.8%	1.2%
16	Сэлэнгэ	6.7%	1.8%	1.1%	3.4%
17	Төв	10.2%	2.9%	0.9%	3.9%
18	Увс	38.5%	20%	20.2%	5.8%
19	Улаанбаатар	0.1%	0.2%	0.2%	0.3%
20	Ховд	0.4%	2.1%	0.4%	0.4%
21	Хөвсгөл	1.9%	0.9%	1.1%	1.3%
22	Хэнтий	1.8%	3.3%	0.2%	0.2%
Дундаж		7.7%	2.6%	1.9%	2.1%

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

1.3. Нэмэлт санал

2023-2026 онд улсын хэмжээнд иргэдээс цахимаар ирүүлсэн нэмэлт санал 2023 онд дунджаар 20% эзэлж байсан бол 2024, 2025 онд 7%, 2026 онд 10%,-тай байна.

- 2023 онд Говьсүмбэр, Орхон, Дархан-Уул, Увс зэрэг аймгуудын иргэдээс ирүүлсэн нэмэлт саналууд 83%-93% хүртэл буюу хамгийн өндөр байна.
- 2024 онд Увс аймгийн нэмэлт санал 30.3%-д хүрч, бусад аймгуудтай харьцуулахад хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна.
- 2025 онд Говьсүмбэр, Увс, Орхон аймгуудын иргэдээс ирүүлсэн нэмэлт санал 25%-33% хүртэл буюу хамгийн өндөр байна.
- 2026 онд Орхон аймгийн нэмэлт саналын хувь өмнөх жилүүдтэй харьцуулахад дөрөв дахин буюу 89%-д хүрсэн байна.

Хүснэгт 4. Нэмэлт саналын эзлэх хувь (2023-2026 он)

№	Аймаг	Нэмэлт санал			
		2023 он	2024 он	2025 он	2026 он
1	Архангай	9.6%	5.9%	6.4%	7.2%
2	Баян-Өлгий	14.4%	11.9%	3.8%	4.9%
3	Баянхонгор	1.3%	1.8%	0.9%	0.9%
4	Булган	19.7%	4.1%	2.1%	5.3%
5	Говь-Алтай	3.3%	8.4%	2.9%	7.5%
6	Говьсүмбэр	92.9%	2.7%	32.5%	4.1%
7	Дархан-Уул	78.3%	4.9%	3.4%	23.9%
8	Дорноговь	1.8%	3.4%	3.1%	4.9%
9	Дорнод	2.8%	6.4%	2.9%	2.9%
10	Дундговь	14.6%	3.1%	1.3%	2.5%
11	Завхан	6%	2.2%	4.3%	3.4%
12	Орхон	83.3%	6%	25.2%	88.9%
13	Өвөрхангай	5.8%	5.9%	3%	4.8%
14	Өмнөговь	6.9%	3.4%	3%	2.7%
15	Сүхбаатар	8.5%	13.2%	13.5%	7.9%
16	Сэлэнгэ	11.2%	2.9%	3%	15.4%
17	Төв	13.4%	8.3%	5.5%	10.8%
18	Увс	61.5%	30.3%	31.2%	16.2%
19	Улаанбаатар	2.5%	3.2%	2.2%	3.6%
20	Ховд	1.6%	11.1%	4.4%	1.1%
21	Хөвсгөл	5.6%	3.5%	2.4%	8.7%
22	Хэнтий	6%	2.1%	0.7%	0.6%
Дундаж		20.5%	6.6%	7.2%	10.4%

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

ХОЁР. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНД ЭРЭМБЭЛЭГДСЭН БОЛОН БАТЛАГДСАН ТӨСЛИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Сангийн сайдын 2021 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмыг баталсан. Уг журмаар ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцогч талуудын чиг үүрэг, баг, хороо, сум, дүүргийн түвшинд төлөвлөлт хэрхэн зохион байгуулагдах талаар тодорхой тусгасан. Журмын дагуу ОНХС-ийн хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн үйл ажиллагаа дараах үе шаттайгаар хэрэгждэг. Үүнд:

ОНХС-ийн хэрэгжилтийн үе шатууд:

1. Баг/хорооны иргэдээс санал авах (1-6 дугаар сард);
2. Сум/дүүрэг санал эрэмбэлэх үе шат (7 дугаар сард багтаана);
3. Сум/дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэх;
4. Сум/дүүргийн ИТХ-аар батлах үе шат (12 дугаар сар);
5. Сум/дүүрэг худалдан авалт, хэрэгжилт хийх үе шат (дараа онд);
6. Бүх үе шатанд иргэд мэдээлэл авах болон иргэдийн оролцоотой хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх эрхтэй.

Гүйцэтгэлийн үе шат:

Тухайн шатны ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжид заасны дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гүйцэтгэнэ.


Тайлагналын үе шат:

1. Баг/хорооны Засаг дарга нь сум/дүүргийн ЗДТГ-тай хамтран өмнөх оны ОНХС-ийн үйл ажиллагааны үр дүн, тухайн онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэхээр батлагдсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний талаарх дэлгэрэнгүй танилцуулгыг дараагийн төсвийн жилийн аймаг, нийслэл, сум дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан тэргүүлэх ач холбогдолтой хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл, арга хэмжээний танилцуулгын хамт бэлтгэж баг, хороо, сум, дүүргийн мэдээ мэдээллийн хэрэгслээр дамжуулан жил бүрийн 2 дугаар сард багтаан олон нийтэд танилцуулна.
2. Сум/дүүргийн Засаг дарга нь ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтад иргэдийн өгсөн санал багтсан болон багтаагүй шалтгааныг тухайн саналыг ирүүлсэн баг/хорооны Засаг даргаар дамжуулан иргэдэд заавал мэдээлнэ (Сангийн яам, 2021.5.24).

График 3-т 21 аймгийн орон нутгийн хөгжлийн санд иргэдээс ирүүлсэн саналуудыг эрэмбэлсэн байдал болон тухайн эрэмбийн дагуу ИТХ-аас батлагдсан төслүүдийн харьцуулалтыг үзүүлэв. Иргэдийн санал олонхын дэмжлэг авч, эрэмбийн дарааллаар жагссан хэдий ч ИТХ-ын шийдвэрээр өөрчлөгдөх, эсвэл батлагдаагүй тохиолдлууд ажиглагдаж байна. Энэ нь төсөл сонголтын эцсийн шийдвэр зөвхөн саналын тоонд үндэслэгдэхгүй бөгөөд орон нутгийн хөгжлийн бодлогын чиглэл, салбарын тэргүүлэх зорилт, санхүүгийн боломж, мөн тухайн жилийн хөрөнгө оруулалтын хүрээ, шаардлага зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэж, батлагддаг байна.

2018-2020, 2023-2024 онд орон нутгийн хэмжээнд эрэмбэлэгдсэн төслүүдээс бага төсөл ИТХ баталж байсан бол 2021, 2022 онд эрэмбэлэгдсэн төслүүдээс олон тооны төсөл ИТХ баталжээ.

График 3. Аймаг, орон нутгийн хөгжлийн санд иргэдээс ирүүлсэн саналын үндсэн дээр эрэмбэлэгдсэн төслүүд болон ИТХ-аас батлагдсан төслүүдийн зөрүү



Тайлбар: Хасах утгатай тоон зөрүүг хаалтанд харуулсан

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

2018-2024 онд 21 аймгийн иргэдээс ирүүлсэн саналаас ажлын хэсгийн үнэлгээгээр эрэмбэлэгдсэн төслүүдийн тоог доорх хүснэгтэд харуулав.

Иргэдээс ирүүлсэн саналд үндэслэн эрэмбэлэгдсэн төслийн тоо жилээс жилд тогтмол өссөн хандлагатай байна. 2018 онд нийт 1,768 төсөл эрэмбэлэгдсэн бол 2024 онд энэ тоо 8,216-д хүрч, 4.6 дахин нэмэгдсэн байна.

Хүснэгт 5. Орон нутгийн хөгжлийн санд иргэдээс ирүүлсэн саналаас эрэмбэлэгдсэн төслүүдийн тоо (2018-2024 он)

№	Аймаг	Эрэмбэлэгдсэн төслүүд						
		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Архангай	3	292	321	267	335	346	383
2	Баян-Өлгий	14	265	285	159	167	355	412
3	Баянхонгор	73	258	269	289	344	532	615
4	Булган	61	162	126	112	291	369	408
5	Говь-Алтай	65	216	187	186	295	379	445
6	Говьсүмбэр	43	51	77	63	53	39	88
7	Дархан-Уул	5	143	149	57	95	164	151
8	Дорноговь	13	390	322	274	173	206	177
9	Дорнод	129	249	230	262	269	393	666
10	Дундговь	73	206	167	129	214	281	241
11	Завхан	94	340	319	205	288	421	476
12	Орхон	32	44	46	79	86	116	99
13	Өвөрхангай	98	314	269	232	290	404	395
14	Өмнөговь	233	182	217	222	288	344	328
15	Сүхбаатар	24	116	182	170	212	352	349
16	Сэлэнгэ	37	82	75	110	128	258	477

17	Төв	175	195	239	168	233	297	307
18	Увс	63	127	367	130	239	291	454
19	Ховд	219	311	366	315	305	534	744
20	Хөвсгөл	227	310	375	224	388	678	647
21	Хэнтий	87	330	216	241	240	305	354
Нийт		1,768	4,583	4,804	3,894	4,933	7,064	8,216

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

Хүснэгт 6-д 2018-2024 онд 21 аймгийн хэмжээнд иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлэн ИТХ-аар батлагдсан төслүүдийн тоог харуулав.

2018 онд нийт 1,233 төсөл батлагдаж байсан бол 2024 онд 7,234 болж 6 дахин өссөн байна.

Хүснэгт 6. Аймгийн эрэмбэлэгдсэн төслүүдээс ИТХ-аар батлагдсан төслийн тоо (2018-2024 он)

№	Аймаг	ИТХ-аар батлагдсан төслүүд						
		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Архангай	4	135	192	206	284	236	260
2	Баян-Өлгий	4	189	316	349	329	441	535
3	Баянхонгор	92	304	308	324	378	467	454
4	Булган	63	152	140	128	237	307	334
5	Говь-Алтай	62	169	229	181	334	232	405
6	Говьсүмбэр	23	43	75	46	49	45	97
7	Дархан-Уул	4	159	109	61	62	143	258
8	Дорноговь	17	116	136	142	147	143	143
9	Дорнод	134	269	286	221	294	290	345
10	Дундговь	67	197	166	214	290	232	254
11	Завхан	65	277	280	271	387	469	509
12	Орхон	53	78	97	90	93	163	348
13	Өвөрхангай	18	183	215	191	268	224	241
14	Өмнөговь	66	132	167	173	242	258	304
15	Сүхбаатар	18	112	146	236	281	342	300
16	Сэлэнгэ	38	77	98	152	96	186	230
17	Төв	80	157	233	171	262	263	291
18	Увс	77	138	211	174	236	321	454
19	Ховд	159	251	280	424	565	635	753
20	Хөвсгөл	146	290	292	327	468	500	482
21	Хэнтий	43	177	171	228	178	133	237
Нийт		1,233	3,605	4,147	4,309	5,480	6,030	7,234

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

Хүснэгт 7-д 2018-2024 онд 21 аймгийн хэмжээнд эрэмбэлэгдсэн төслүүдийн тоо болон ИТХ-аар батлагдсан төслүүдийн хоорондын зөрүүг тоон утгаар үзүүлэв. Энд хасах утга нь эрэмбэлэгдсэн төслүүдээс ИТХ нь илүү төсөл баталсан болохыг, харин эерэг утга нь ИТХ нь эрэмбэлэгдсэн төслөөс бага төсөл баталсан гэдэг утгыг илэрхийлнэ.

Нийт аймгуудын хэмжээнд авч үзвэл 2021 болон 2022 онд иргэдийн саналаар эрэмбэлэгдсэн төслөөс илүү олон төслийг ИТХ-аас баталсан харагдаж байна.

Аймаг тус бүрээр харахад Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Ховд аймгууд эрэмбэлэгдсэн төслүүдийн тооноос илүү тооны төсөл ИТХ-аар батлагдах хандлага тогтмол

байгаа нь ажиглагдаж байна. Сүүлийн 7 жилээс дээрх аймгууд 4-6 жилд нь эрэмбэлэгдсэн төслүүдээс илүү тооны төсөл ИТХ-аар батлагдсан байна.

Түүнчлэн Орхон аймаг 2018-2024 оны хооронд жил бүр эрэмбэлэгдсэн төслийн тооноос илүү олон тооны төсөл ИТХ-аар батлагдсан онцлогтой байна. Харин он оноор харвал,

- 2018 онд Архангай, Баянхонгор, Булган, Дорноговь, Дорнод, Сэлэнгэ, Увс аймгуудад эрэмбэлэгдсэн төслүүдийн тооноос илүү тооны төслийг ИТХ-аас баталсан.
- 2019 онд Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Орхон, Увс аймгуудад эрэмбэлэгдсэн төслүүдийн тооноос илүү тооны төслийг ИТХ-аас баталсан.
- 2020 онд Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Орхон, Сэлэнгэ аймгуудад эрэмбэлэгдсэн төслүүдийн тооноос илүү тооны төслийг ИТХ-аас баталсан.
- 2021 онд Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Дундговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгуудад эрэмбэлэгдсэн төслүүдийн тооноос илүү тооны төслийг ИТХ-аас баталсан.
- 2022 онд Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Завхан, Орхон, Сүхбаатар, Төв, Ховд, Хөвсгөл аймгуудад эрэмбэлэгдсэн төслүүдийн тооноос илүү тооны төслийг ИТХ-аас баталсан.
- 2023 онд Баян-Өлгий, Говьсүмбэр, Завхан, Орхон, Сүхбаатар, Төв, Ховд, Хөвсгөл аймгуудад эрэмбэлэгдсэн төслүүдийн тооноос илүү тооны төслийг ИТХ-аас баталсан.
- 2024 онд Баян-Өлгий, Говьсүмбэр, Дархан-Уул, Дундговь, Завхан, Орхон аймгуудад эрэмбэлэгдсэн төслүүдийн тооноос илүү тооны төслийг ИТХ-аас баталсан байгааг харуулж байна.

Хүснэгт 7. Орон нутгийн хөгжлийн санд иргэдээс ирүүлсэн саналын үндсэн дээр эрэмбэлэгдсэн төслүүд болон ИТХ-аар батлагдсан төслүүдийн зөрүү (аймгаар)


№	Аймаг	Зөрүү						
		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Архангай	-1	157	129	61	51	110	123
2	Баян-Өлгий	10	76	-31	-190	-162	-86	-123
3	Баянхонгор	-19	-46	-39	-35	-34	65	161
4	Булган	-2	10	-14	-16	54	62	74
5	Говь-Алтай	3	47	-42	5	-39	147	40
6	Говьсүмбэр	20	8	2	17	4	-6	-9
7	Дархан-Уул	1	-16	40	-4	33	21	-107
8	Дорноговь	-4	274	186	132	26	63	34
9	Дорнод	-5	-20	-56	41	-25	103	321
10	Дундговь	6	9	1	-85	-76	49	-13
11	Завхан	29	63	39	-66	-99	-48	-33
12	Орхон	-21	-34	-51	-11	-7	-47	-249
13	Өвөрхангай	80	131	54	41	22	180	154
14	Өмнөговь	167	50	50	49	46	86	24
15	Сүхбаатар	6	4	36	-66	-69	10	49
16	Сэлэнгэ	-1	5	-23	-42	32	72	247
17	Төв	95	38	6	-3	-29	34	16
18	Увс	-14	-11	156	-44	3	-30	0
19	Ховд	60	60	86	-109	-260	-101	-9
20	Хөвсгөл	81	20	83	-103	-80	178	165
21	Хэнтий	44	153	45	13	62	172	117
Нийт		535	978	657	-415	-547	1034	982

ГУРАВ.ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛААС БАТЛАГДСАН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ ТҮҮНИЙ САНХҮҮЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

Графикт 4-т 2018-2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн төслүүдийн нийт төсөвт өртөг болон тухайн онд санхүүжүүлсэн мөнгөн дүнг харьцуулан, эдгээр хоёр үзүүлэлтийн хоорондын зөрүүг хувиар илэрхийлэн харвал жил бүр төсөвт өртгөөс өндөр санхүүжилт хийгдсэн байна.

- 2018 онд нийт төсөвт өртөг 24.1 тэрбум төгрөг, харин санхүүжих дүн 37.2 тэрбум буюу төсөвт өртгөөс тухайн оны санхүүжилт 54%-аар өндөр байна;
- 2019 онд нийт төсөвт өртөг 78.2 тэрбум төгрөг, санхүүжих дүн 270.4 тэрбум буюу төсөвт өртгөөс тухайн оны санхүүжилт 246%-аар өндөр байна;
- 2020 онд нийт төсөвт өртөг 123.0 тэрбум төгрөг, санхүүжих дүн 168.6 тэрбум буюу төсөвт өртгөөс тухайн оны санхүүжилт 37%-аар өндөр байна;
- 2021 онд нийт төсөвт өртөг 172.6 тэрбум төгрөг, санхүүжих дүн 227.0 тэрбум буюу төсөвт өртгөөс тухайн оны санхүүжилт 32%-аар өндөр байна;
- 2022 онд нийт төсөвт өртөг 230.6 тэрбум төгрөг, санхүүжих дүн 288.4 тэрбум буюу төсөвт өртгөөс тухайн оны санхүүжилт 25%-аар өндөр байна;
- 2023 онд нийт төсөвт өртөг 359.9 тэрбум төгрөг, санхүүжих дүн 454.8 тэрбум буюу төсөвт өртгөөс тухайн оны санхүүжилт 26%-аар өндөр байна;
- 2024 онд нийт төсөвт өртөг 609.5 тэрбум төгрөг, санхүүжих дүн 778.7 тэрбум буюу төсөвт өртгөөс тухайн оны санхүүжилт 28%-аар өндөр байна.

График 4. Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас батлагдсан төсөвт өртөг болон санхүүжилт, тэдгээрийн зөрүү (төгрөгөөр)



Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

Орон нутгийн хөрөнгө оруулалтыг Малын тоо, толгойн албан татвараар болон ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлдэг байна.

Хүснэгт 8-д 2018–2024 онд малын тоо толгойн албан татвар болон ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хэмжээг үзүүлэв.

Малын тоо толгойн албан татварын тухай хууль нь 2021 оноос хэрэгжиж эхэлсэн бөгөөд тус оноос эхлэн малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг хүснэгтэд оруулав. 2021-2024 оны хооронд малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлсэн арга хэмжээний санхүүжилт жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

Мөн адил, ОНХС-аар санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний нийт санхүүжилт 2018–2024 оны хооронд тогтвортой өссөн байна.

Хүснэгт 8. Орон нутгийн хөрөнгө оруулалт

№	Он	Малын тоо толгойн албан татвар	ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ	Нийт
1	2018		37,211,058,443	37,211,058,443
2	2019		270,460,363,893	270,460,363,893
3	2020		168,653,746,022	168,653,746,022
4	2021	119,060,510	226,913,299,187	227,032,359,697
5	2022	7,698,386,386	280,737,133,926	288,435,520,312
6	2023	28,077,913,469	426,775,646,252	454,853,559,721
7	2024	31,553,395,188	747,225,846,991	778,779,242,179

Эх сурвалж: Сангийн яамнаас ирүүлсэн мэдээллийг судлаачийн боловсруулснаар.

Хүснэгт 9-д 2018-2024 онд ОНХС-аар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний төсөвт өртөг болон тухайн онд бодитоор санхүүжүүлсэн хэмжээний хооронд үүссэн зөрүүг аймаг тус бүрээр харьцуулан үзүүлэв.

Эдгээр хоёр үзүүлэлтийг харьцуулахад жил бүр ОНХС-аар бодитоор санхүүжүүлсэн хэмжээ нь анх төлөвлөсөн төсөвт өртгөөс давсан байна.

Хүснэгт 9. ОНХС-аар хэрэгжүүлэх арга хэмжээний төсөвт өртөг болон тухайн онд санхүүжүүлсэн хэмжээний хоорондын зөрүү (аймгаар)

№	Аймаг/нийслэл	Зөрүү						
		2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Архангай	-215,255,791	-349,538,281	-315,045,292	-458,081,089	-715,974,987	-415,810,636	-3,545,819,600
2	Баян-Өлгий	-3,000,000,000	-947,388,300	-1,187,129,146	-5,002,283	-93,888,839	-290,518,068	-1,259,769,318
3	Баянхонгор	-6,384,467,800	-8,506,245,852	-13,079,427,585	-15,295,942,676	-5,761,821,423	-8,062,265,392	-17,520,094,800
4	Булган	-92,020,702	-850,823,200	-1,494,242,826	-1,741,260,720	-1,129,414,100	-2,055,708,199	-3,973,888,630
5	Говь-Алтай	-	-235,100,900	-2,014,715,081	196,587,000	-3,414,961,029	-351,263,684	-3,455,119,671
6	Говьсүмбэр	-5,400,000	-	-	24,000,000	-	-	-106,429
7	Дархан-Уул	-	-156,449,217,947	-4,588,730,301	-4,914,097,719	-3,994,096,700	-6,064,876,215	-26,969,882,517
8	Дорноговь	-1,497,981	-296,152,912	-8,282,191,809	-271,365,256	-567,895,800	-718,574,858	-11,221,263,400
9	Дорнод	-249,417,800	-2,524,435,562	-1,625,554,200	-2,942,703,181	-6,261,266,652	-7,785,978,680	-24,885,840,991
10	Дундговь	-30,407,600	-27,891,201	-1,201,419,512	-308,420,675	-986,142,465	-11,490,566,951	-8,243,252,300
11	Завхан	-3,000,000	-225,778,459	-509,540,981	-750,987,766	-1,285,261,047	-152,715,269	105,928,549
